



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд Нисэх буудлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2025/004/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Нарандэлгэр

Утас: 86001147 Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Зөвлөмж.....	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ИНЕГ	Иргэний Нисэхийн ерөнхий газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД НИСЭХ БУУДЛЫН ДАРГА
Б.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА

2025.03.15 № 2/110

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд нисэх буудлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд нисэх буудлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд мэргэжлийн байгууллагуудаар ажлын байрны эрсдэлийн үнэлгээг 5 ажлын байранд 23.5 сая төгрөгөөр, захиргааны хэсгийн ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2.5 сая төгрөгөөр тус тус хийлгэсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Ховд нисэх буудал нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг төлөвлөж, 89.0 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****(төгрөгөөр)**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,237,973.51	91,337.19
1.1.2	Дансны авлага	5,867,546.97	19,452,089.84
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	29,651.20	0
1.1.4	Бусад авлага	0	7,000,000.00
1.1.6	Бараа материал	208,666,920.57	219,732,772.21
	Эргэлтийн хөрөнгийн дүн	224,802,092.25	246,276,199.24
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,749,494,161.40	2,007,378,068.54
1.2.2	Биет бус хөрөнгө	13,279,388,884.00	13,261,730,710.43
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	44,919,808.05	40,719,847.14
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,073,802,853.46	15,309,828,626.11
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,298,604,945.71	15,556,104,825.35
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0	601,017.76
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0	601,017.76
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0	601,017.76
2.3	Эздийн өмч	14,118,976,376.17	13,474,667,593.87
2.3.1	Өмч: - төрийн	13,259,898,000.00	13,259,898,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	859,078,376.17	214,769,593.87
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг	12,771,666.34	0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,166,856,903.20	2,080,836,213.71
	Эздийн өмчийн дүн	16,298,604,945.72	15,555,503,807.59
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,298,604,945.71	15,556,104,825.35

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**(төгрөгөөр)**

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1.1	Борлуулалтын орлого	67,624,828.17	77,994,887.93
	Буулт хөөрөлтийн орлого	14,376,236.34	47,535,177.99
	Буудлын хураамж	7,043,151.19	11,937,914.00
	Үнэмлэх борлуулсны орлого	190,000.00	0
	Газрын техник үйлчилгээний орлого	20,227,830.00	0
	Шатахуун тээвэрлэлтийн орлого	3,200,311.34	3,099,329.60
	Санхүүжилтийн орлого	21,879,299.30	12,771,666.34
	Үйл ажиллагааны бусад орлого	708,000.00	2,650,800.00
	Борлуулалтын орлогын дүн	67,624,828.17	77,994,887.93
1.2	Борлуулалтын өртөг	2,577,438,197.62	3,162,385,396.74
	Бичиг хэрэг	2,663,368.20	4,286,073.53
	Албан конторын зардал	1,359,536.36	3,494,036.36
	Шатахуун	93,026,538.94	123,315,898.32

	Үндсэн цалин	563,879,460.43	735,469,071.14
	Илүү цаг	10,464,190.18	28,712,201.44
	Амралтын мөнгө	80,495,757.40	92,120,128.23
	Цалингийн бусад нэмэгдэл	288,049,865.11	362,797,795.97
	Үндсэн ба нэмэгдэл цалингийн нийт дүн	942,889,273.12	1,219,099,196.78
	Хоолны үнийн хөнгөлөлт	134,295,000.00	224,850,000.00
	Нийгмийн даатгалын зардал (Үйлдвэрлэл)	145,250,695.29	194,292,376.07
	Сэлбэг засвар-Барилга	43,658,581.82	23,411,010.20
	Сэлбэг засвар-Автомашин	6,945,400.00	28,773,925.01
	Сэлбэг засвар-Аэродром	37,980,073.89	54,577,980.42
	Сэлбэг засвар -ТТ	32,840,059.97	37,069,879.08
	Сэлбэг засвар	121,424,115.68	143,832,794.71
	Цахилгаан	30,898,858.07	38,612,913.63
	Дулаан	53,538,204.92	101,635,711.70
	Усны зардал	2,600,000.00	6,434,000.00
	Холбооны зардал	7,662,954.49	5,259,410.50
	Ашиглалтын зардлын дүн	94,700,017.48	151,942,035.83
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	846,360,297.78	832,297,960.73
	Биет бус хөрөнгийн хорогдуулга	17,657,058.36	17,658,173.57
	Элэгдлийн зардлын дүн	864,017,356.14	849,956,134.30
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	26,531,848.43	33,117,431.24
	Газрын татвар	29,480,830.81	21,258,598.00
	Тээврийн хэрэгслийн татвар	290,000.00	534,725.00
	Хөрөнгийн даатгал	8,230,000.00	24,870,676.80
	Татвар, даатгалын зардлын дүн	64,532,679.24	79,781,431.04
	Хөдөлмөр хамгаалал	28,418,747.21	32,857,701.12
	Дотоод сургалтын зардал	1,138,272.73	1,090,727.27
	Сургалтын зардлын дүн	1,138,272.73	1,090,727.27
	Дотоод томилолт	44,635,627.73	76,101,407.22
	Албан томилолтын зардлын дүн	44,635,627.73	76,101,407.22
	Харуул хамгаалалт	796,681.84	5,925,749.95
	Цэвэрлэгээний зардал	6,549,021.01	12,882,063.33
	Гал команд	27,190,272.82	27,892,727.27
	Тээврийн зардал	200,000.00	2,022,100.00
	Ачаа тээврийн зардал	175,000.00	0
	Үйлдвэрлэлийн бусад зардал	4,175,993.83	8,762,943.64
1.3	Нийт ашиг (алдагдал)	-2,509,813,369.45	-3,084,390,508.81
1.4	Үйл ажиллагаа (Борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	4,320,000.00	5,400,000.00
	Аудит баталгаажуулалтын зардал	4,320,000.00	5,400,000.00
1.5	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-2,514,133,369.45	-3,089,790,508.81
2	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	1,673,024,503.83	2,338,461,037.02
2.6.1	Бусад үйл ажиллагааны бус орлого	1,758,066,324.82	2,478,705,369.78
	Хүүгийн орлого	140,023.56	287,047.35
	Бусад үйл ажиллагааны бус орлого	2,354,600.00	2,186,819.95
	Санхүүжилт орлого	1,683,446,500.00	2,245,934,000.00
	Систем хоорондын тооцоогоорх орлого	72,125,201.26	135,579,583.66
	ҮХ-н дотоод хөдлөлийн борлуултын олз	0	94,717,918.82

2.6.2	Бусад үйл ажиллагааны бус зардал	85,041,820.99	140,244,332.76
	Тэтгэмж	3,149,999.99	2,375,000.00
	Түлшний хөнгөлөлт	2,000,000.00	3,400,000.00
	Банкны үйлчилгээний зардал	245,824.91	106,900.02
	Спорт арга хэмжээний зардал	0	11,232,545.45
	Эмнэлэг үйлчилгээний зардал	2,400,000.00	4,681,072.00
	Үйл ажиллагааны бус бусад зардал	14,000.99	28,704.73
	Систем хоорондын тооцоогоорх зардал	67,774,020.96	61,645,877.78
	ҮХ-н дотоод хөдлөлийн борлуултын гарз	9,457,974.14	56,774,232.78
2.3	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн	1,673,024,503.83	2,338,461,037.02
3	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-841,108,865.62	-751,329,471.79
4	Татварын дараах ашиг (алдагдал)	-841,108,865.62	-751,329,471.79
5	Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)	-841,108,865.62	-751,329,471.79
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-841,108,865.62	-751,329,471.79

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	13,259,898,000.00	859,078,376.17	12,771,666.34	2,166,856,903.20	16,298,604,945.72
3	Залруулсан үлдэгдэл	13,259,898,000.00	859,078,376.17	12,771,666.34	2,166,856,903.20	16,298,604,945.72
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0
6	Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0	0
7	Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0
9	2023 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	13,259,898,000.00	859,078,376.17	12,771,666.34	2,166,856,903.20	16,298,604,945.72
11	Залруулсан үлдэгдэл	13,259,898,000.00	859,078,376.17	12,771,666.34	2,166,856,903.20	16,298,604,945.72
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	-751,329,471.79	-751,329,471.79
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0
14	Өмчид гаргасан өөрчлөлт	0	644,308,782.30	12,771,666.34	665,308,782.30	8,228,333.66
15	Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0
17	2024 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	13,259,898,000.00	214,769,593.87	0	2,080,836,213.71	15,555,503,807.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,738,254,451.49	2,300,231,399.67
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	36,705,439.75	50,847,489.66
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,195,748.80	0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,683,446,500.00	2,248,300,000.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	14,906,762.94	1,083,910.01
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,744,639,123.06	2,310,665,083.34
1.2.1	Ажиллагчдад төлсөн	934,596,417.86	1,309,669,287.53
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	247,907,448.86	298,925,488.79
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	341,165,166.80	214,372,146.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	43,209,184.01	58,859,525.21
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	14,000.99	28,704.73
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	27,950,100.00	210,788,150.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	141,460,979.63	154,824,385.26
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,230,000.00	24,870,676.80
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	105,824.91	38,326,719.02
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-6,384,671.57	-10,433,683.67
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	140,023.56	287,047.35
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	140,023.56	287,047.35
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-4,961,236.44	287,047.35
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-11,345,908.01	-10,146,636.32
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-11,345,908.01	-10,146,636.32
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,583,881.52	10,237,973.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,237,973.51	91,337.19

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
НИЙТ ЗАРЛАГА	1,747,829,481.30	2,445,107,800	2,307,344,923.34	
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	1,747,829,481.30	2,445,107,800.00	2,307,344,923.34	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ	1,742,679,481.30	2,430,057,800.00	2,297,025,851.34	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,081,539,507.18	1,514,810,300.00	1,441,884,276.25	
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	911,244,507.18	1,229,230,900.00	1,172,807,276.25
2	Унаа хоолны хөнгөлөлт	134,295,000.00	241,302,400.00	224,850,000
4	Гэрээт ажлын цалин	36,000,000.00	44,277,000.00	44,227,000
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,512,678.16	202,369,200.00	195,493,719.09	
1	Тэтгэврийн даатгал	87,961,877.16	128,758,900.00	124,371,081.97
2	Тэтгэмжийн даатгал	10,905,870.00	15,148,100.00	14,631,892.25

3	ҮОМШӨ-ний даатгал	19,472,165.95	23,615,000.00	21,178,979.63
4	Ажилгүйдлийн даатгал	2,015,705.97	4,551,000.00	6,594,630.74
5	Эрүүл мэндийн даатгал	20,157,059.08	30,296,200.00	28,717,134.50
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		108,803,666.07	141,222,000.00	110,922,344.47
1	Гэрэл, цахилгаан	32,137,466.07	53,352,000.00	41,498,844.47
2	Түлш, халаалт	75,740,000.00	80,010,000.00	62,829,500
3	Цэвэр, бохир ус	926,200.00	7,860,000.00	6,594,000
Хангамж, бараа материалын зардал		118,029,200.94	171,452,800.00	166,355,459.74
1	Бичиг хэрэг	2,618,700.00	4,708,000.00	4,531,000
2	Тээвэр, шатахуун	100,803,800.00	137,064,800.00	136,773,880
3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,596,189.94	9,700,000.00	5,627,326.74
4	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,510,521.00	15,000,000.00	14,679,803
5	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	499,990.00	4,980,000.00	4,743,450
Эд хогшил, урсгал засварын зардал		173,648,319.80	205,278,200.00	191,407,201
Багаж, техник, хэрэгсэл		85,431,810.00	123,960,200.00	111,460,897
1	Тоног төхөөрөмж	20,451,260.00	24,030,000.00	23,690,597
2	Автомашин	6,829,260.00	32,227,200.00	31,759,050
3	Аэродром	29,772,290.00	28,489,000.00	27,141,250
4	Гал унтраах	28,379,000.00	39,214,000.00	28,870,000
5	Хөдөлмөр хамгааллын зардал	31,250,621.00	30,018,000.00	28,912,150
6	Урсгал засвар	56,965,888.80	51,300,000.00	51,034,154.00
Томилолт, зочны зардал		43,135,850.00	78,644,500.00	78,644,200
	Дотоод албан томилолт	43,135,850.00	78,644,500.00	78,644,200
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		70,696,556.15	100,633,000.00	93,941,651
1	Харуул, хамгаалалтын зардал	1,809,052.00	7,890,000.00	7,549,615.00
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	33,727,981.24	33,272,300.00	33,112,031.24
3	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,320,000.00	5,473,000.00	5,400,000
4	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,597,000.00	1,100,000
5	Даатгалын үйлчилгээ	8,230,000.00	25,000,000.00	24,870,677
6	Тээврийн хэрэгслийн татвар	1,135,500.00	1,240,700.00	534,725
9	Газрын төлбөр	21,228,198.00	24,920,000.00	21,238,998
10	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	245,824.91	240,000.00	135,604.75
Бараа үйлчилгээний бусад зардал		6,313,703.00	15,647,800.00	18,377,000

1	Бараа үйлчилгээний бусад зардал	4,423,703.00	14,547,800.00	17,177,200
	Сургалт семинар	1,890,000.00	1,100,000.00	1,199,800
	Дотоод сургалт	1,890,000.00	1,100,000.00	1,199,800
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,150,000.00	15,050,000.00	10,319,072.00
	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,150,000.00	7,850,000.00	4,176,072
1	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	2,750,000.00	-	-
2	Эмчилгээний зардал	2,400,000.00	7,200,000.00	6,143,000
	НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН ДҮН	1,735,064,093.25	2,477,957,700.00	2,297,198,287.02
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	51,617,593.25	32,850,000.00	51,264,287.02
1	Буулт, хөөрөлтийн орлого	51,147,569.69	24,000,000.00	47,535,177.99
2	Зорчигч үйлчилгээний орлого		2,850,000.00	3,312,311.67
3	Бусад орлого	470,023.56	6,000,000.00	416,797.36
	НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН	1,683,446,500.00	2,445,107,700.00	2,245,934,000
	Улсын төсвөөс санхүүжих	1,683,446,500.00	2,445,107,700.00	2,245,934,000

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,750.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 1,750.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,750.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийсэн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний төлбөрийг шилжүүлэхдээ 1,750.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд түлш халаалтын зардалд тендер зарлаагүй, 2 аж ахуйн нэгжтэй шууд худалдан авах гэрээг байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түлш халаалтын зардалд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ховд Нисэх буудал	Тайлант онд ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийсэн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний төлбөрийг шилжүүлэхдээ 1,750.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн,	1	1,750.0	1	1,750.0						
	Тайлант онд түлш халаалтын зардалд тендер зарлаагүй, 2 аж ахуйн нэгжтэй шууд худалдан авах гэрээг байгуулсан	1	-						1	-	
ДҮН		2	1,750.0	1	1,750.0	-	-	1	-		

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТӨҮГ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР